



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/323

Алтай хот

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилттэй Цээл сумын шинэ суурьшлын бүсийн худгийн автомат төхөөрөмж, иж бүрэн тохижилтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	П. Хулан	-(Төрийн захиргааны удирдлагын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	А.Наранбаатар	-(Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
	Ё.Нарангарав	-(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
	Б.Доржготов	-(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичиг:	Ц.Анхбаяр	-(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (П.Хулан)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ